

СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН ХЭЛ НАЙРУУЛГЫН АСУУДАЛД
/Зохиолч, сэтгүүлч До.Цэнджавын сэтгүүл зүйн бүтээлийн жишээгээр/

Д. Батжаргал, С. Содгэрэл *

Сонирхолтой, шинэлэг, өгөөжтэй... Энэ бол сэтгүүл зүйн бүтээлийн гол шалгуурууд. Мэдээ бол хамгийн сүүлийн үеийн шуурхай, дуулиан шуугиантай үйл явдал, олны танил үзэгдэл, хүн, юмсын тухай шинэ сонин баримт байдаг бол, өгүүлэлд зөрчил маргаантай үйл явдал, асуудалд олон түмний анхаарал хандуулах, уншигч сонсогч, үзэгчдийн хүсэн хүлээж байгаа асуудлыг сөхөн тавих гэх мэт шаардлага шалгуурууд байвч гол нь дээрх гурав. Сонирхолтой бичиж гэмээж нь уншигчтай байна. ДойчиВелле телевизийн сэтгүүлч Петер Стайш монголын сэтгүүлчдэд сургалт хийхдээ “Ярилцлага яагаад гэсэн асуултаас эхэлж байвал сайн” гэж номлож байсан нь хоосон хэрэггүй үг биш. Уншуулахын тулд тэр шүү дээ.

Тэгвэл До.Цэнджавын сэтгүүл зүйн бүтээлүүд салахын аргагүй уншууртай юм. Үнэхээр **асгаж, цутгаж, цалгитал** бичих юм. “Он цагийн шастир” номонд Л.Түдэв гуайтай хийсэн ярилцлага гэхэд долоон хэсэгтэй, 27 асуулттай. Арваад жилийн өмнө хийсэн ярилцлага мөртлөө одоо ч уншихад сонирхолтой. Ялангуяа ярилцлага дотроос нь “Дэвшил ба дэглэм” гээд бичээдэтвэл диктатур тогтоох нь гэж гуйвуулсан. Гэтэл тэр хүсээд байгаа капитализмын чинь гол хууль нь дэглэм шүү дээ. Дэглэмгүй том үйлдвэр гэж байдаг юмуу? Замбараагүй тавьсан хүн адгуус болдог. Аав ээжийгээ ч егүүтгэдэг¹. гэсэн хэдэн үгий аваад үзье. Үнэхээр хэрэгтэй үг. Одоо энэ үг ямар үнэ цэнэтэй байгааг эргэцүүлэн бодмоор. Өнгөрсөн онд, бүр тодруулбал 2015.10.22-ны нэгэн шөнө эмэгтэй хүний таксид барингуут жолооч нь замаасаа нэг хүн аваад хоёр залуу түүнийг дээрэмдэн зодож ухаан алдуулаад жалганд хаясан хэрэг гарсан. Хохирогч нь эмнэлэг домлого гээд явж байхад үйлдэгчид нь дээрмийн мөнгөөрөө тансаглаж явах. Ийм хүний ёс, л харгис хажар нийгэм гэж байх уу. Ерөөс дүрэм журмаа чангатган эмх цэгцэндээ орохгүй бол Монгол улс монголоо алдаж гүйцэж байна. Хаа хаанаа дэглэм журамдаа ормоор байна. Үүнийг олон түмэн хүсч байна.

Тухайн цаг үедээ МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга зэрэг дээрээсээ бараг хоёр дахь хүн гэгдэж явсан хэрнээ гэнэтхэн улстөрийн эсэргүү Ц.Төмөр-Очирын хамсаатан гэдэг хэргээр хэлмэгдэж хөдөө суманд газар заагдан хөөгдөж явсан олон үйл хэргийн гэрч болох Сампилын Жалан- Аажав гуайтай хийсэн

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

¹ Цэнджав До (2010), “Он цагийн шастир”, УБ., 38-р тал.

“Түүхийн хуудаснаас үнэнийг арчиж устгаж болдоггүй” ярилцлагыг асуултууд эвлэг зөөлөн байдлаар эх сурвалжийн “хөлд нь суун” дотоод ертөнцийг уудалсан нь амттай юм. “Үүрэг даалгавраа гялалзтал биелүүлдэг, ажлаа арван хуруу шигээ мэддэг, бүх талаар товойсон, үнэхээр нэг урам төрмөөр сайхан хүн байдаг шүү дээ. Өнөөдөр та надтай ярилцахдаа хэнийг дурсмаар байна?”, “Одоо та хоёр хааяа уулзаад дундаа нэг шил юм тавьчихаад хуучилж ярилцдаг уу?”, “Үгүй, би чинь эсэргүү болоод 10 гаруй жил явчихсан хүн. Тэднийг би их айлгасан даа. Эсэргүү хүнтэй их нийлвэл хоолноосоо сална шүү дээ?”, “-Та Моломжамц гуайг магтаад байдаг. Өөрөө ч олигтой үг хэлэхгүй юм. Гэтэл Ю. Цэдэнбалын ойрын тойрон хүрээлэгч гээд ширүүхэн байсан шүү дээ?” гэх мэтээр мярайн “дөхөж” очсон байх юм. Ингэсээр ингэсээр амыг нь халааж яриа илүү дотно сайхан хөөрөлдөөнд хүрч бүүр цаашлаад “Таныг Төмөр- Очирын хамсаатан гэсэн гол хэргээр төрийн эсэргүү болгосон. Дахин ярилцах боломж гараа ч уу, үгүй ч үү, энэ хүний талаар тогтоож ярилцмаар байна? –Та намайг нэлээд тулгаж байна. Зөв өө. Сэтгүүлч хүний ажлын онцлогийг би мэднэ...”² гэх зэргээр ярилцсан байх жишээтэй. Социализмын хатуу хяналт дор, төр засгийн том алба хашиж явсан эрхэмнээс хэн ч асууж зүрхлэмгүй асуултыг эвийг олоод асуучихдаг. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэгт хүнийг хөөргөж онгиоож байгаад хэлэхгүй юмыг нь хэлүүлчихдэг айхтар улс юм гэж олон түмэн шуугиж байна. Дотор байгаа хэлэхийг тэр бүрий хүсдэггүй үгийг нь яриулна гэдэг амаргүй. Ийм түлхүүр сэтгүүлчид л байдаг.

До.Цэнджав **халтал, хөөртөл, хөөсөртөл** бичнэ. Монголын нэртэй яруу найрагч Б.Доржпаламын тухай “Омскийн дэлт чоно” хөрөг нь нэрнээсээ эхлээд уншигчийн сонирхол татна. Хүнийг чонотой зүйрлэлээ гэж хэн ч үл гайхах. Яагаад гэвэл энэ нэрийг далаад оны Мандалговийнхон өгсөн болохоос хөрөг бичигч санаанаасаа зохиогоогүй. Харин энэ нэрийг хөргийн гарчиг болгож аваад түүндээ дүйцтэл бичиж яруу найрагчийн омголон хөөрүү занг дурайтал зурсан нь шүлэгтэй газар нь шүлгийг нь, нулимстай газар нь нулимсыг нь дуслуулж өгсөн нь яахын аргагүй том ололт. Хөрөг бичвэр эхлэхдээ “Далаад оны сурагч биднийг Мандалговь хотын 10 жилийн сургуулийн дотуур байранд байхад нэг аймшигт амьтан гэнэт гараад ирлээ. Гашиун нясуун юм сэнгэнүүлээд энэ тэрийг сэжигтэй ажсан эвгүй харцтай, шилээ дарсан урт үстэй, орос хороом гутлын түрүйггармуушиглан дарсан, улаан эрээн ороолт хайшийш унжуулсан олигор хар нөхөр хаанаас гараад ирснийг мэдэхгүй, тэрийг ч дэлсэж гэнэ, үүнийг ч ичээж айлгаж гэнэ, тэрний хоолойд хутга тулгаж гэнэ гэсэн дэл сул яриа хаа сайгүй дуулдах болов. Нэр ч байхгүй. ”Омскийн дэлт чоно” л гэнэ. Үнэхээр аюумшигт ”дэлт чоно” гэвэл тэр мөнөөсөө мөн байлаа. Царай зүс арай гайгүй охидыг эргүүлнэ, тоохгүй бол яаж ч магадгүй ийм хачин дээрэнгүй хүн гараад иржээ” хэмээн уншигчаа гайхширтал омог сүртэй лийд хийжээ. Тайлалыг их сайхан хийнэ. “Гэтэл тэрхүү “Омскийн дэлт” буюу бидэнд шар ус хуруулсан аймшигт амьтан маань Барнангийн Доржпалам хэмээх авьяаслаг яруу найрагч болсон юмсанж” Монгол ахуйг сайхан дүрсэлдэг уран бүтээлч байсныг бид мэднэ. “Миний ээжийн шар гал” гэж ямар сайхан шүлэг байдгийг монголын яруу найрагт хайртай уншигчид мартаагүй байх.

Тэрбээр **дүрсэлж, зураглаж, харагдтал** өгүүлж чадна. Хүний дүрийг ч нүднээ үзүүлж эх орны байгаль нутаг ус, тэр тусмаа тэмээ бөмбөлзүүлж наран дуниартсан говь нутгаа харагдаж халуун нар нь төөнөтөл сайхан зураглана. Таана сэнгэнүүлсэн тал нутгийн зөөлөн салхи нүүр илбэн, хараа алдран цэлийсэн уудам тал өөрийн эрхгүй

² Цэнджав До (2010), “Он цагийн шастир”, УБ.,

нүднээ тусна. “Гэрийн маань урдуурхан салаа замаар ”жаран ес” үе үе сүр бараатай өнгөрнө. Машины хойноос харж зогсох дуртай байлаа. Тоос нь чамгүй удаж замхардаг болохоор цөөнгүй машин байгаа биз. Тэгээд л аагим халуунд хонио услахаар худаг руу дүүгээ дагуулан сажилдагсан. Гадаад дотоодын томоохон дарга, зочид тэртээ зүүнтээ тэнгэрийн хаяанд хөрөөний ир шиг ирийн цэнхэртэх Их газрын чулууг ёс юм шиг заавал үздэг байлаа.

Өөрөө нэгэнтээ “Дундговьтсурганы кабинетын эрхлэгч байхдаа багш нарын бага хуралд тавих илтгэлийг машин дээр шууд бичихэд Аюур, Мөнхдалай нар гайхдагсан. Гайхах юмгүй. Би үзгээр барагтай бол бичиж чадахгүй болчихож. Нэг л удаан... үг хойно хойноосоо овоорч бөглөрөөд л түрүүчээсээ хулжаад алга болно. Заримдаа үзгээ аваад чулуудчихмаар санагддаг. Компьютер бол түүний дэргэд тэмээгээр явж байгаад машинд суухын дайтай урамтай юм гээч. Хамгийн гол нь үгээ засаж болдог нь даанч урамтай” гэж дурссан бий. Баримтаа хангалттай цуглуулж оюундаа олон дахин холбируулан боддог, сэтгэлдээ бичдгийн жишээ энэ.

Цэнджав **зангирч, ончирч, догдолж** бичнэ. Үг сонголтыг сайн олох юм. Адал явдлын тэмдэглэл хүртэл бичсэн байх юм. Бяр зааж эрч цэнэг хуримтлуулж мэдлэг түгээж бичих юм. “Маргааш дайн эхэлчих юм шиг 1080 хоног” хэмээх эссе баримтат туужид уншигчийн сонирхол татах, гижиг инээдийг хүргэх хэсэг олон бий.

Оюутны байрны тухай хэсэгт “...Буцалж байгаа үхрийн хавиргыг тэр чигээр нь “Сүхбаатар” киноны Гомбо шиг цувныхаа суганд хийгээд явчихыг харахад гайхмаар шүү. Ялангуяа манай тамирынхан аймшигтай махчид. Батхуяг чоно хоёрыг адил гэдэгсэн. Тэрбээр хар багаасаа өнчирсөн, “сургуулийн” гэх овогтой хээгүй, ил цагаан сэтгэлтэй, айх ичих юмгүй марзан бадриун том эр гал тогооны үүдээр нэг хавираад өнгөрсөн бол нэг байтугай түмпэн хоол юу ч үгүй ховх сорогдоно. Халуун хоолыг тийм амархан, тэгээж түүртэлгүй иддэг хүн бас байдгаа гэж гайхишрмаар...”³ гэж бичснийг уншихаар дал, наяд оны оюутны амьдрал нүдэнд тусаад ирнэ.

Ерөөс **нотолж, баталж, үнэмшүүлж** бичих юм. Жишээ нь “Нарангийн хувилгаанийг хүмүүжүүлэх гээд навс хүмүүжигдсэн түүх”, “15 дугаар жилийн наадам” зэрэг бүтээлд олон жилийн өмнөх үйл явдлыг уншигчийн ой тойнд буулган бичсэн байх юм. “Жанжин Дэмид урд хоёр хөлийн шилбийг тууз мэт торгоор жимбийтэл ороосон өндөр хүрэн тоомсог морины жолоо юугий нь бага зэрэг татасхийгээд тэр нь дороо бүжиглэх мэт цөмцөгнөж алхаж гишгэх нь мөн ч жавхаатай сүрлэг харагддагсан. Дэмид маршалын гоёмсог хувцсан дээр одонгоо зүүчихсэн яралзтал инээхэд алтан шүд нь тод их л содон харагддагсан. Жанжныг хаана л явна хүн шаваад байна. Олны хайр, анхаарлыг татдаг онцгой сонин увидастай хүн байж дээ гэж би одоо боддог”⁴ хэмээн эдүгээгээс наян жилийн тэртээхийг дүрслэн харуулсан байна.

Ардын хэлээр **амталж давсалж чимж** жор хужрыг нь тааруулж бичих юм. Сэтгүүл зүйн бичлэгийн бүх төрлөөр даацтай сайн бичих юм. “Өвсөнд ороовч үхэр тоохгүй, өөхөнд боовч нохой тоохгүй”, “хоноц хоноцдоо дургүй, хонуулсан айл хоёуланд нь дургүй” гэх зэрэг олныг дурдаж болмоор болно. Бичгийн их хүн Чой. Лувсанжав багш маань “Хэл бол салхи, бичиг бол мөр” гэсэн үгийг би хэлэх дуртай. Байнга бичиж өөрийнхөө дасгалжуулж хол ойрыг харьцуулан, үүх түүхийг гаргаж ирж сонирхолтойгоор дэлгэн тавьж Монголын агаар амьсгалд буулган монгол оюуны

³ Цэнджав До (2014), “Тэнгэрт хальсан тоос”, УБ., 609-610-р тал.

⁴ Цэнджав До (2010), “Он цагийн шастир”, УБ., 309-р тал.

сэтгэхүүд нийцүүлэн бичдэг нь сэтгүүлч, доктор профессор До.Цэнджавын эрлийн үр дүн, бичлэгийн онцлог юм. Энэ Америкийн тухай тэмдэглэлүүд зэрэг олон бүтээлээс нь харагдана.

Сэтгүүл зүйн хэл муудаж байна. Хэдхэн жилийн өмнө монголын сэтгүүл зүйд орж ирсэн “Хонгилын үзүүрт гэрэл харагдана”, “амь тариа”, “ногоон гэрлээр гарах”, “цагаан захтан”, “хэрүүлийн алим”, “матрын нулимс”, “загалмайлсан эцэг”, “лааз өшиглөх”, “хор найруулах”, “луу унжих”, “хуулийн цоорхой”, “цус сэлбэх”, “ходоодоороо сонгуульд оролцох” гэх мэт үгсийг төвөггүйхэн ойлгож таньдаг болоод багагүй хугацаа өнгөрчээ⁵. гэж доктор О.Шинэбаяр, Э.Пүрэвжав нар шүүмжилж байсан. Өнөөдөр ч бас шүүмжилж л байна. Цаашдаа ч шүүмжилж таарна. Би түүний эсрэг магтаал хэлэх гэсэн юм. **Та бүхэн уран зохиолын хэлний тухай ярьчихлаа гэж бүү бодоорой. Харин уран зохиол шиг амттай сэтгүүл зүйн хэлний тухай ярьсан шүү.** Боловсролын их сургуулийн багш, профессор Ж.Батбаатар, доктор С.Амартүвшин нар “Сэтгүүлчийн ур чадвар” номдоо “Утга зохиолын хэлний бичгийн болон “завсрын” шинжийг агуулсан, янз бүрийн түвшний боловсролтой хүмүүс, хэрэглэгчдэд зориулагдсан хамгийн “энгийн” ойлгомжтой, тодорхой уран сайхны болон шинжлэх ухааны хэл найруулгаас ангид хэл зүйн хэм хэмжээг баримталсан байх нь сэтгүүл зүйн хэл найруулгын үндсэн шаардлага болдог”⁶ гэж хэлсэн байдаг.

Сайн бичвэрүүдийг эталон болгон тавьж байж сайжирна. Сэтгүүл зүйн ном сурах бичигт олон оруулах хэрэгтэй. Монголын сэтгүүлчдийн байгууллагаас гаргаж байгаа сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн түүвэрт До.Цэнджавын бүтээл харагдахгүй байна. Сүүлийн үед нэлээд оруулж байгаа боловч сонголт нь харилцан адилгүй байна. Орон нутгийн сэтгүүлчдийн сайн бүтээлээс оруулдаг алдаршуулдаг байх хэрэгтэй. Уран сайхан бичлэгийг шалгаруулдаг жишиг тогтоож болох юм. Сэтгүүл зүйн ном хаялцдаг, үнэтэй маргаан мэтгэлцээн өрнүүлдэг байж ч болох юм.

НОМ ЗҮЙ

1. Амартүвшин. С, Батбаатар. Ж (2014), “Сэтгүүлчийн ур чадвар” УБ.,
2. Хэлний соёлын тулгамдсан асуудлууд (2010) УБ.,
3. Цэнджав. До “Буурал ээжийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” УБ.,
4. Цэнджав. До (2010), “Он цагийн шастир” УБ.,
5. Цэнджав. До (2014), “Тэнгэрт хальсан тоос” УБ.,

SUMMARY

Tsendjav Dolgor is one of the few people who have created fictional characters and descriptions. His style in journalistic writing is more fictional but never crosses the line. If we set high standards of journalistic writing such as his writings, the language of journalism can improve.

⁵ ШУА, ХЗХ (2010), “Хэлний соёлын тулгамдсан асуудлууд” УБ., 105-106-р тал

⁶ Амартүвшин. С, Батбаатар. Ж (2014), “Сэтгүүлчийн ур чадвар”, УБ., 21-р тал